



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Халиун сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ГАА-2026/044/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Алтай хот  
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа

Утас: 99998431 Цахим хаяг: [gunjidmaag@audit.gov.mn](mailto:gunjidmaag@audit.gov.mn)

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 99175677 Цахим хаяг: [erdenechimegd@audit.gov.mn](mailto:erdenechimegd@audit.gov.mn)

Ахлах аудитор: Э.Сүнжидмаа

Утас: 80048599 Цахим хаяг: [Sunjidmaae@audit.gov.mn](mailto:Sunjidmaae@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,  
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091  
Утас: (976) 7048-4030,  
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2026.02.15 № 101

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Халиун сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

- Тайлант онд 4,950.0 мянган төгрөгийн компьютер бэлтгэхдээ цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй,
- Батлагдсан төсөвт тусгасан 39,433.3 мянган төгрөгийн шатахуун худалдан авахдаа тендер зохион байгуулаагүй,
- Малжуулах хөтөлбөрт хамрагдсан зарим малчин өрхүүдтэй гэрээ байгуулаагүй, гэрээний хугацаа дууссан боловч сунгаагүй, тооллогын баримтад малыг бөөн дүнгээр бүртгэсэн,
- Байгууллагын кассаар зарцуулсан нийт 13,912.0 мянган төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, кассын тайлан гаргаагүй,
- Өмнөх онд хийсэн санхүүгийн болон нийцлийн аудитаар өгсөн шийдвэрийг хэрэгжүүлээгүй байна.

822505000287

ХАЛИУН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
А.ӨНӨРБАЯР ТАНАА

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.7 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4 дэх заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.4, 13.7 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалын хавсралтын 19 дүгээр зүйлийн 19.2 дахь заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

#### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд 2000 гаруй мод тарьсан ба голын эхнээс татсан шуудууг сэргээн засварласан байна. Мөн Ёлтонгийн услалтын системийг бүрэн хүчин чадлаар ашиглаж эхэлсэн байна.

#### **Аудитын гол асуудал**

Тайлант онд орон нутгийн төсвийн санхүүжилт 1,029,802.5 мянган төгрөгөөр батлагдсан нь өмнөх оноос 71,212.8 мянган төгрөгөөр өссөн байна.

#### **Бусад асуудал**

Тайлант онд 8 хөтөлбөр, 81 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 57 арга хэмжээг бүрэн, 20 арга хэмжээг 70 хувь, 3 арга хэмжээ 50 хувь, үнэлэх боломжгүй 1 арга хэмжээ, нийт дүнгээр 90.6 хувийн гүйцэтгэлтэй байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэгдэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>323,816,427.27</u></b>	<b><u>372,726,710.27</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	14,168,465.00	28,535,248.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	14,366,783.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	14,168,465.00	14,168,465.00
33510	Байгууллагаас авах авлага	14,168,465.00	14,168,465.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	198,337,562.27	207,881,062.27
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	104,364,442.27	113,907,942.27
35410	Бичиг хэргийн материал	667,000.00	2,482,000.00
35420	Аж ахуйн материал	103,697,442.27	108,930,942.27
35450	Барилгын засварын материал	-	2,495,000.00
35600	Мал амьтад	93,973,120.00	93,973,120.00
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	111,310,400.00	136,310,400.00
36200	Үрийн нөөц	106,010,400.00	106,010,400.00
36300	Тэжээлийн нөөц	5,300,000.00	30,300,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>6,366,884,434.52</u></b>	<b><u>11,654,518,368.53</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	6,366,884,434.52	11,654,518,368.53
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	2,241,390,634.52	7,529,024,568.53
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,253,990,314.78	1,288,890,314.78
39202	Хуримтлагдсан элэгдэл	(190,093,291.39)	(228,228,285.71)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	262,405,800.00	481,904,236.28
39204	Хуримтлагдсан элэгдэл	(172,303,799.56)	(211,174,399.86)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	280,924,424.54	3,397,341,537.29
39206	Хуримтлагдсан элэгдэл	(130,904,093.37)	(474,713,408.66)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	48,071,481.00	59,071,481.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(31,731,072.76)	(38,677,144.34)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,275,299,840.99	3,891,836,406.99
39215	Хуримтлагдсан элэгдэл	(354,699,869.71)	(637,657,069.24)
39217	Ном	430,900.00	430,900.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	4,125,493,800.00	4,125,493,800.00
39301	Программ хангамж	2,480,000.00	2,480,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,730,000.00)	(1,730,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	4,124,743,800.00	4,124,743,800.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>6,690,700,861.79</u></b>	<b><u>12,027,245,078.80</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>50,431,521.18</u></b>	<b><u>40,589,350.94</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	50,431,521.18	40,589,350.94
<b>413</b>	<b>Өглөг</b>	50,431,521.18	40,589,350.94
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	23,883,350.94
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	-	16,706,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	2,366,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	14,340,000.00

<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>6,640,269,340.61</u></b>	<b><u>11,986,655,727.86</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	6,640,269,340.61	11,986,655,727.86
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	418,800,564.27	418,800,564.27
51101	Өмч: - төрийн	418,800,564.27	418,800,564.27
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>6,017,259,204.87</b>	<b>11,363,645,592.12</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	5,951,721,900.29	6,008,939,204.87
51220	Тайлант үеийн үр дүн	65,537,304.58	5,354,706,387.25
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	204,209,571.47	204,209,571.47
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>6,690,700,861.79</u></b>	<b><u>12,027,245,078.80</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,292,688,426.99</b>	<b>7,102,914,400.03</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>300,733,519.81</b>	<b>6,035,102,115.03</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	300,733,519.81	6,035,102,115.03
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	262,689,461.54	5,993,402,115.03
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	5,418,057.27	41,700,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>991,954,907.18</b>	<b>1,067,812,285.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	33,365,247.00	38,009,785.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18,423,904.00	2,717,483.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	14,941,343.00	35,292,302.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	958,589,660.18	1,029,802,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	958,589,660.18	1,029,802,500.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,227,151,122.41</b>	<b>1,748,208,012.78</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,227,151,122.41</b>	<b>1,748,208,012.78</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,191,620,612.88	1,720,438,409.71
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	615,478,343.62	643,709,885.81
210101	Үндсэн цалин	371,155,817.00	390,128,714.53
210102	Нэмэгдэл	198,467,458.14	223,767,618.37
210104	Урамшуулал	2,365,400.00	18,543,595.10
210105	Гэрээт ажлын хөлс	6,632,449.40	11,269,957.81
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	102,818,292.06	120,617,245.72
210201	Тэтгэврийн даатгал	90,609,747.98	56,856,764.25

210202	Тэтгэмжийн даатгал	1,604,811.46	37,989,030.09
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,302,905.73	4,678,095.41
210204	Ажилгүйдлийн даатгал	3,951,872.38	4,000,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,348,954.51	17,093,355.97
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	60,247,765.21	68,753,798.16
210301	Гэрэл, цахилгаан	9,122,581.21	7,589,414.16
210302	Түлш, халаалт	51,125,184.00	61,104,384.00
210303	Цэвэр, бохир ус	-	60,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	70,785,866.97	68,082,550.00
210401	Бичиг хэрэг	7,152,900.00	5,388,600.00
210402	Тээвэр, шатахуун	54,861,816.97	45,860,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,384,750.00	3,487,950.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	420,000.00	607,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,966,400.00	878,700.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	-	11,860,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	16,345,185.00	8,248,000.00
210604	Урсгал засвар	16,345,185.00	8,248,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	9,788,800.00	5,296,000.00
210702	Дотоод албан томилолт	9,788,800.00	5,296,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	9,368,472.00	5,268,330.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,077,000.00	4,137,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	604,800.00	403,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	488,480.00	115,830.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогчоо	143,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	450,000.00	590,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	306,787,888.02	800,462,600.02
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	131,250,625.00	87,664,419.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,600,000.00	2,080,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	166,937,263.02	710,718,181.02
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	35,530,509.53	27,769,603.07

<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>		
		28,647,500.00	3,595,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,999,500.00	3,595,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>		
		6,883,009.53	24,174,603.07
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,883,009.53	24,174,603.07
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>65,537,304.58</u></b>	<b><u>5,354,706,387.25</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>65,537,304.58</u></b>	<b><u>5,354,706,387.25</u></b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>1,058,080,908.18</u></b>	<b><u>1,053,445,502.00</u></b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b><u>1,055,954,907.18</u></b>	<b><u>1,053,445,502.00</u></b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	97,365,247.00	23,643,002.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	82,423,904.00	2,717,483.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	14,941,343.00	20,925,519.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	958,589,660.18	1,029,802,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	958,589,660.18	1,029,802,500.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>1,017,811,908.18</u></b>	<b><u>1,048,495,502.00</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b><u>1,017,811,908.18</u></b>	<b><u>1,048,495,502.00</u></b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b><u>982,281,398.65</u></b>	<b><u>1,020,725,898.93</u></b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	615,478,343.62	643,709,885.81
210101	Үндсэн цалин	371,155,817.00	390,128,714.53
210102	Нэмэгдэл	198,467,458.14	223,767,618.37
210104	Урамшуулал	2,365,400.00	18,543,595.10
210105	Гэрээт ажлын хөлс	6,632,449.40	11,269,957.81
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	54,971,740.85	171,048,766.90
210201	Тэтгэврийн даатгал	42,763,196.77	107,288,285.43
210202	Тэтгэмжийн даатгал	1,604,811.46	37,989,030.09
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,302,905.73	4,678,095.41
210204	Ажилгүйдлийн даатгал	3,951,872.38	4,000,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,348,954.51	17,093,355.97
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	60,247,765.21	52,934,647.22
210301	Гэрэл, цахилгаан	9,122,581.21	7,046,359.22
210302	Түлш, халаалт	51,125,184.00	45,828,288.00
210303	Цэвэр, бохир ус	-	60,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	68,458,316.97	50,848,350.00
210401	Бичиг хэрэг	7,245,900.00	5,629,100.00

210402	Тээвэр, шатахуун	53,526,266.97	39,433,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,384,750.00	3,425,250.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	420,000.00	607,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,881,400.00	1,753,700.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>16,021,785.00</b>	<b>15,471,500.00</b>
210604	Урсгал засвар	16,021,785.00	15,471,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>9,788,800.00</b>	<b>5,296,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	9,788,800.00	5,296,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>10,179,297.00</b>	<b>5,136,030.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,887,825.00	4,005,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	604,800.00	403,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	488,480.00	115,830.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	143,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	450,000.00	590,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>147,135,350.00</b>	<b>76,280,719.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	136,535,350.00	74,200,719.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,600,000.00	2,080,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>35,530,509.53</b>	<b>27,769,603.07</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>28,647,500.00</b>	<b>3,595,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,999,500.00	3,595,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>6,883,009.53</b>	<b>24,174,603.07</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,883,009.53	24,174,603.07
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>40,269,000.00</u></b>	<b><u>4,950,000.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>40,269,000.00</b>	<b>4,950,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>40,269,000.00</b>	<b>4,950,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>40,269,000.00</b>	<b>4,950,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	40,269,000.00	4,950,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(40,269,000.00)</u></b>	<b><u>(4,950,000.00)</u></b>

#### 2.4 Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

( төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	418,800,564.27	204,209,571.47	5,951,721,900.29	6,574,732,036.03
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	418,800,564.27	204,209,571.47	5,951,721,900.29	6,574,732,036.03

C07	Тайлант үеийн үр дүн	-	-	65,537,304.58	65,537,304.58
C08	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>418,800,564.27</b>	<b>204,209,571.47</b>	<b>6,017,259,204.87</b>	6,640,269,340.61
D01	<b>2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>418,800,564.27</b>	<b>204,209,571.47</b>	<b>6,017,259,204.87</b>	6,640,269,340.61
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(8,320,000.00)	(8,320,000.00)
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>418,800,564.27</b>	<b>204,209,571.47</b>	<b>6,008,939,204.87</b>	6,631,949,340.61
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	5,354,706,387.25	5,354,706,387.25
D09	<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>418,800,564.27</b>	<b>204,209,571.47</b>	<b>11,363,645,592.12</b>	11,986,655,727.86

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

код	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,086,151,900.0</b>	<b>1,029,802,500.6</b>	56,349,399.4	94.8
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,086,151,900.0	1,019,994,679.9	66,157,220.1	93.9
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,080,951,900.0	1,016,399,679.93	64,552,220.1	94.0
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	666,793,500.0	643,709,885.81	23,083,614.2	96.5
210101	Үндсэн цалин	374,009,600.0	390,128,714.53	(16,119,114.5)	104.3
210102	Нэмэгдэл	231,477,600.0	223,767,618.37	7,709,981.6	96.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	32,003,600.0	18,543,595.10	13,460,004.9	57.9
210104	Урамшуулал	29,302,700.0	11,269,957.81	18,032,742.2	38.4
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	144,099,300.0	171,048,766.90	(26,949,466.9)	118.7
210201	Тэтгэврийн даатгал	81,187,600.0	107,288,285.43	(26,100,685.4)	132.1
210202	Тэтгэмжийн даатгал	15,727,900.0	37,989,030.09	(22,261,130.1)	241.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,982,400.0	4,678,095.41	9,304,304.6	33.4
210204	Ажилгүйдлийн даатгал	8,745,600.0	4,000,000.00	4,745,600.0	45.7
210205	Эрүүл мэндийн даатгал	24,455,800.0	17,093,355.97	7,362,444.0	69.8
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	76,956,100.0	52,934,647.22	24,021,452.8	68.7
210301	Гэрэл, цахилгаан	13,056,100.0	7,046,359.22	6,009,740.8	53.9
210302	Түлш, халаалт	63,500,000.0	45,828,288.00	17,671,712.0	72.1
210303	Цэвэр, бохир ус	400,000.0	60,000.00	340,000.0	15.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	71,654,800.0	50,848,350.00	20,806,450.0	70.9
210401	Бичиг хэрэг	7,400,000.0	5,629,100.00	1,770,900.0	76.0
210402	Тээвэр, шатахуун	53,800,000.0	39,433,300.00	14,366,700.0	73.3

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,924,000.0	3,425,250.00	498,750.0	87.2
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,000,000.0	607,000.00	393,000.0	60.7
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,300,000.0	1,753,700.00	1,546,300.0	53.1
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	2,230,800.0	-	2,230,800.0	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	23,800,000.0	20,421,500.00	3,378,500.0	85.8
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,800,000.0	4,950,000.00	850,000.0	85.3
210604	Урсгал засвар	18,000,000.0	15,471,500.00	2,528,500.0	85.9
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	13,356,000.0	5,296,000.00	8,060,000.0	39.6
210702	Дотоод албан томилолт	13,356,000.0	5,296,000.00	8,060,000.0	39.6
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	5,192,200.0	1,131,030.00	4,061,170.0	21.7
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	710,000.0	403,200.00	306,800.0	56.7
210803	Даатгалын үйлчилгээ	202,200.0	115,830.00	86,370.0	57.2
210804	Тээврийн хэрэгслийн татвар	840,000.0	-	840,000.0	-
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	420,000.0	22,000.00	398,000.0	5.2
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	890,000.0	590,000.00	300,000.0	66.2
210807	Газрын төлбөр	2,130,000.0	-	2,130,000.0	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	79,100,000.0	71,009,500.00	8,090,500.0	89.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	72,000,000.0	68,929,500.00	3,070,500.0	95.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,100,000.0	2,080,000.00	5,020,000.0	29.3
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	5,200,000.00	3,595,000.00	1,605,000.0	69.1
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	5,200,000.0	3,595,000.00	1,605,000.0	69.1
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,200,000.0	3,595,000.00	1,605,000.0	69.1
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	-	9,807,820.70	(9,807,820.7)	
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		9,807,820.70	(9,807,820.7)	-
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,086,151,900.0</b>	<b>1,029,802,500.00</b>	56,349,400.0	94.8
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,086,151,900.0	1,029,802,500.00	56,349,400.0	94.8
132001	Орон нутгийн төсвөөс	1,086,151,900.0	1,029,802,500.00	56,349,400.0	94.8

## 2.6 НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>23,643,002.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>23,643,002.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	9,276,219.00

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	4,005,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,005,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	5,271,219.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,271,219.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	14,366,783.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>14,366,783.00</b>
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	14,366,783.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>23,643,002.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	23,643,002.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,717,483.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	20,925,519.00

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

**3.1** Аудитаар 2,061,407.0 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа<sup>1</sup>-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Үнэ төлбөргүй орлогыг 15,000.0 мянган төгрөгөөр, тайлант үеийн үр дүнг 8,320.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.
- Нэмэлт төсвийн дансны бараа үйлчилгээний бусад зардал/210901/ 2,717.5 мянган төгрөгөөр, аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох зардал 210.6 мянган төгрөгөөр зөрүүтэй.
- **Мэдээллийг тусгахгүй орхигдуулсантай холбоотой:**  
Шилэн дансны цахим сайтад байршуулах таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 890,707.0 мянган төгрөгийн 31 мэдээлэл, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө 58,300.0 мянган төгрөгийн 1 мэдээллийг, байгууллагын батлагдсан төсөв 1,086,151.9 мянган төгрөгийн мэдээллийг аудитын явцад нөхөн мэдээлүүлж залруулав.

Залруулагдаагүй 154,777.4 зөрчил илэрсэн нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 154,777.1 мянган төгрөгийн 7 зөрчил<sup>2</sup> илэрч 5 зөвлөмж, 1 зөрчил албан шаардлага, 1 хариуцлага тооцох албан шаардлагыг хүргүүлсэн.

### 3.2 Албан шаардлага

1. Халиун сумын Засаг даргын Тамгын газрын бүртгэлд 93,973.1 мянган төгрөгийн малчин өрхөд тараасан малжуулах хөтөлбөрийн мал бүртгэлтэй байна.

Малын бүртгэлд 32,000.0 мянган төгрөгийн малыг 1 толгойгоор, 25,982.9 мянган төгрөгийн малыг малчин өрхөд өгсөн малжуулах гэрээгүй, 67,990.1 мянган төгрөгийн малын малжуулах гэрээний хугацаа дууссан боловч сунгаагүй, тооллогын баримтад малыг бөөн дүнгээр бүртгэсэн байна.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-т "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 41 дүгээр зүйлийн 41.2.7-т "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана", 20 дугаар зүйлийн 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтөлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Малжуулалтын гэрээний болон бүртгэлийн зөрчлийг арилгах, малжуулах арга хэмжээг зохион байгуулах албан шаардлагыг хүргүүллээ.

2. Өмнөх оны санхүүгийн болон нийцлийн аудитаар өгсөн 2023 оны 01/75, 02/75, 3/75 дугаартай 24,103.5 мянган төгрөгийн акт, 2021 оны 04/134 дугаартай 13,029.9 мянган төгрөгийн, 2023 оны 53/257 дугаартай албан шаардлагын хэрэгжилтийг бүрэн хангаагүй, хугацаанд нь биелүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13-т "албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалын хавсралтын 19 дүгээр зүйлийн 19.2-т "Шалгагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын байгууллагаас өгсөн аудитын шийдвэрийг биелүүлээгүй, төсвийг үр ашиггүй зарцуулж албан үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн Халиун сумын Засаг даргын Тамгын газрын даргын үүргийн түр орлон гүйцэтгэгч А.Өнөрбаярт хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлсэн.

### **3.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **Нэг. Хууль тогтоомжтой холбоотой**

Тайлант онд 4,950.0 мянган төгрөгийн компьютер бэлтгэхдээ цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно.", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цахим дэлгүүрт байршсан тоног төхөөрөмж, барааг бусад этгээдээс худалдан авахгүй байх.

### **Хоёр: Худалдан авах ажиллагаатай холбоотой**

Илрүүлэлт: Тайлант онд 39,433.3 мянган төгрөгийн тээвэр шатахууны зардалд худалдан авахдаа тендер зохион байгуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно." гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Босго үнээс давсан төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ хуулийн дагуу худалдан авах ажиллагаа зохион байгуулж байх.

### **Гурав: Нягтлан бодох бүртгэл, тооцоо судалгаатай холбоотой**

Илрүүлэлт: Цалин зардлын дүн, нийгмийн даатгалд тайлагнасан дүнгээс 1,921.0 мянган төгрөгөөр зөрүүтэй, мал тоологчийн урамшуулал 588.0 мянган төгрөгийг нийгмийн даатгалын тайланд тайлагнаагүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 32 хуулийн 32.2.2-т "орон тоо болон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, сар бүр нийгмийн даатгалын санд төлөх" гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, түүнд тавих хяналтыг сайжруулж, нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн тайлагнах.

### **Дөрөв: Нэмэлт санхүүжилтийн орлоготой холбоотой**

Илрүүлэлт: Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар худгийн орлого "Ундарга-Алтай" ААТҮГ-аас 5,731.0 мянган төгрөг төвлөрсөн байна. Усны картаар үйлчилгээ авсан иргэдээс төвлөрөх орлогыг бүрэн төвлөрүүлсэн эсэх, гэрээ байгуулсан нь тодорхойгүй, орлогын төлөвлөлт хангалтгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-т "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 41 дүгээр зүйлийн 41.2.7-т "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Худгийн орлогын тооцоог анхан шатны баримтад үндэслэн хийж, бүртгэлийг хөтөлж хэвших.

### **Тав: Нягтлан бодох бүртгэл хяналттай холбоотой:**

Илрүүлэлт: Байгууллагын нярвын дансаар дамжуулан нийт 13,912.0 мянган төгрөгийн бэлэн мөнгийг касс авч, анхан шатны нотлох баримтгүй зарцуулж, кассын тайлан гаргаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Говь-Алтай аймгийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн багцын төсөвт байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Тавдугаар бүлэг: Нягтлан бодох бүртгэлийн тусгай бодлого, горим, 5.1 Мөнгөн хөрөнгийн бүртгэл төсөвт байгууллага нь бага хэмжээний

үнийн дүнтэй бараа, ажил үйлчилгээний болон банкны харилцах дансгүй этгээдийн төлбөрийг бэлэн мөнгөөр гүйцэтгэх ба төлбөрийн ний дүн 300,000 төгрөгөөс, тээвэр шатахууны хэмжээ 500,000 төгрөгөөс хэтрэхгүй” гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, түүнд тавих хяналтыг сайжруулж, нярвын дансаар дамжуулан хийх гүйлгээг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд гүйцэтгэх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тайлан хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нээгээл

(мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								тоо	Дүн	тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Халиун сумын Засаг даргын Тамгын газар	Шилэн дансны цахим сайтад байршуулах таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 890,707.0 мянган төгрөгийн 31 мэдээлэл, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө 58,300.0 мянган төгрөгийн 1 мэдээллийг, байгууллагын батлагдсан төсөв 1,086,151.9 мянган төгрөгийн мэдээллийг аудитын явцад нөхөн мэдээлүүлж залруулав.	1	2,035,158.2	1	2,035,158.2	-	-	1	2,035,158.2	-	-	-	-
	Үнэ төлбөргүй орлогыг 15,000.0 мянган төгрөгөөр, тайлант үеийн үр дүнг 8,320.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.	1	23,320.0	-	-	1	23,320.0	1	23,320.0	-	-	-	-
	Нэмэлт дансны бараа үйлчилгээний бусад зардал/210901/ 2717.5 мянган төгрөгөөр, аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох зардал 210.6 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.	1	2,928.1			1	2,928.1	1	2,928.1				
<b>Дүн</b>		<b>3</b>	<b>2,061,407.0</b>	<b>1</b>	<b>2,035,158.2</b>	<b>1</b>	<b>26,248.1</b>	<b>3</b>	<b>2,061,407.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

## 4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Халиун сумын Засаг даргын Тамгын газар	Тайлант онд 4,950.0 мянган төгрөгийн компьютер бэлтгэхдээ цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна.	1	4,697.1	-	-	-	-	1	4,697.1	-	-
	Тээвэр шатахууны зардлын батлагдсан төсөв 39,433.3 мянган төгрөгөөр шатахуун худалдан авахдаа тендер зохион байгуулаагүй байна.	1	39,433.3	-	-	-	-	1	39,433.3	-	-
	Цалин зардлын дүн, нийгмийн даатгалд тайлагнасан дүнгээс 1,921.0 мянган төгрөгөөр зөрүүтэй, мал тоологчийн урамшуулал 588.0 мянган төгрөгийг нийгмийн даатгалын тайланд тайлагнаагүй байна.	1	2,509.0	-	-	-	-	1	2,509.0	-	-
	Халиун сумын Засаг даргын Тамгын газрын бүртгэлд тусгасан 93,973.1 мянган төгрөгийн малын гэрээг тулгаж үзэхэд 32,000.0 мянган төгрөгийн малыг 1 толгойгоор, 25,982.9 мянган төгрөгийн мал гэрээгүй, 67,990.1 мянган төгрөгийн малын гэрээний хугацаа дууссан боловч сунгаагүй, тооллогын баримтад малыг бөөн дүнгээр бичсэн байна.	1	93,973.1	-	-	1	93,973.1	-	-	-	-
	Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар худгийн орлого "Ундарга-Алтай" ААТҮГ-аас 5,731.0 мянган төгрөг төвлөрсөн байна.	1	-	-	-	-	-	-	1	-	-

Халиун сумын Засаг даргын Тамгын газар	Усны картаар үйлчилгээ авсан иргэдээс төвлөрөх орлогыг гэрээгээ байгуулсан эсэх нь тодорхойгүй, орлогын төлөвлөлт хангалтгүй байна.										
	Байгууллагын нярвын дансаар нийт 13,912.0 мянган төгрөгийг касст бэлэн авч, анхан шатны нотлох баримтгүй зарцуулж, кассын тайлан гаргаагүй байна.	1	13,912.0	-	-	-	-	1	13,912.0	-	-
	Өмнөх оны санхүүгийн болон нийцлийн аудитаар өгсөн 2023 оны 01/75, 02/75, 3/75 дугаартай 24,103.5 мянган төгрөгийн акт, 2021 оны 04/134 дугаартай 13,029.9 мянган төгрөгийн, 2023 оны 53/257 дугаартай албан шаардлагын хэрэгжилтийг бүрэн хангаагүй, хугацаанд нь биелүүлээгүй байна.	1	-	-	-	-	-	-	-	1	-
<b>Нийт</b>		<b>7</b>	<b>154,777.4</b>	-	-	<b>1</b>	<b>93,973.1</b>	<b>5</b>	<b>60,804.3</b>	<b>1</b>	<b>-</b>

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>				<b>1</b>		